Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,453,479.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 222,793.1 мянган төгрөг,төсөвт байгууллагын өөрийн орлого 35,024.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 571,941.1 мянган төгрөг нийт 5,283,238.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,573,513.9 мянган төгрөг буюу 86.57 хувьтай байгаа нь байр ашиглалтай холбоотой тогтмол зардлыг гүйцэтгэлээр орон нутаг төсвөөс санхүүжилтийг олгож, ашиглалтын зардлын төсвийн хэмнэлт 28,564.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,453,479.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 33,138.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,573,513.8 мянга төгрөг буюу 86,57 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 709,724.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71802-80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 12,499.2 | 12,315.0 | (184.2) | 98.53 |
| 2 | 71802-80312 Сургалт семинар | 11,487.2 | 4,684.8 | (6,802.4) | 40.78 |
| 3 | 71802-81605 Эрүүл мэндийг дэмжих | 23,325.9 | 6,442.0 | (16,883.9) | 27.62 |
| 4 | 71802-81801 Үдийн цай хөтөлбөр | 348,332.2 | 316,633.5 | (31,698.7) | 90.90 |
| 5 | 71802-81816 Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 102,445.5 | 100,032.0 | (2,413.5) | 97.64 |
| 6 | 71802-81823 Боловсролын байгууллагын багш , ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 42,249.3 | | (42,249.3) | 0.0 |
| 7 | 71802-81834 Боловсролын стандарт , сургалтын төлөвлөгөө , хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 4,316,001.8 | 3,840,870.4 | (475,131.4) | 88.99 |
| 8 | 71802-81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 128,714,3 | 128,714.3 | - | 100.00 |
| 9 | 71802-81844 гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах | 18,760.4 | 14,594.9 | (4,165.5) | 77.79 |
| 10 | 71802-81848 Сурах бичгийн түрэс | 13,824.6 | 13,824.6 | - | 100.00 |
| 11 | 71802-81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр | 28,228.4 | 13,816.9 | (14,411.5) | 48.95 |
| 12 | 71802-80233 Хүүхэд хамгаалал | 11,876.2 | 4,375.0 | (7,501.2) | 36.84 |
| 13 | 71802-8011 Төрийн өмчийн байгууллагын тогтмол , урсгал зардал | 225,493.1 | 117,210.5 | (108,282.6) | 85:74 |
| | дүн | 5,283,238.1 | 4,573,513.9 | (709,724.2) | 86.57 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Ахмадын сан байгууллаагүй байна.

ХАА судалгаа- 2024 онд 98,282.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авсан.

210801 - Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардал 13,824.6 мянган төгрөг түрээсийн сурах бичиг.

210901 - Багшийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, багшийн сургалтын зардал, ариутгал цэвэрлэгээний бодис худалдан авах, дотоод албан томилолт,бага үнэтэй түргэн элэгдэх зардал, бичиг хэрэг,интернэтийн зардал, аудит, төлбөр хураамжийн зардлууд багтсан ба нийт 198,676.6 мянган төгрөг зарцуулсан.

Орон тооны судалгаа 2024 онд батлагдсан орон тоо төлөвлөгөөгөөр 128, гүйцэтгэлээр орон тоо 139 ажилтантай ажиллаж байгаа нь шинэ байранд орсонтой холбоотой байна. Тус сургууль нь 2024-2025 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийн дагуу математика-1 , физик-1 , гадаад хэлний багш -2 , бага ангийн сургалтын менежер -1 , сэтгэл зүйч -1, сургуулийн шинэ өргөтгөлийн байр ашиглалтанд орсоноор шинээр жижүүр -3 , үйлчлэгч -2 нийт 11 орон тоо нэмэгдэж 139 багш , ажилсагчидтай сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулсан.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

***3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн***

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд Боловсрол -2032 хөтөлбөр 9-р сургуулийн спорт заалны засварын ажлыг ОН2411900050 тоот гэрээний дагуу "Софт солар энержи " ХХК нь гүйцэтгэж ,2024 оны12 дугаар сарын 16-ны өдөр ОН2411900050 дугаар актаар "Софт солар энержи " ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг ашиглалтанд хүлээн авахаар дүгнэлт гарч. Гэрээнд заасаны дагуу гүйцэтгэлд 287,679,584.00 / Хоёр зуун наян долоон сая зургаан зуун далан ёсөн мянга таван зуун наян дөрвөн / төгрөг олгох , гэрэээтэй холбоотой харилцаа дуусгавар болгосоноор дүгнэлт гарч ,Боловсрол-2032 хөтөлбөр 9-р сургуулийн спорт заалны засварын зардал -287,679.5 мянган төгрөгийг / хөрөнгөнд бүртгэх захирамж шийдвэр баталгаажуулаагүй , мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 320 хүүхдийн сургуулийн барилга байгууламжинд Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01/-А-313 дугаар шийдвэрээр байгуулагдсан 19 хүний бүрэлдхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 5 сарын 14-ны дүгнэлт , гэрээний дугаар БШУЯ/202212023+1 ,. гүйцэтгэгч Минж пропорти ХХК , барилга байгууламжийн гүйцэтгэлийн нийт дүн -7,345,534,957.00 /Долоон тэрбум гурван ззун дөчин таван сая таван зуун гучин дөрвөн мянга есөн зуун тавин долоон /төгрөгийн хөрөнгийг бүртгэх тогтоол шийдвэр баталгаажуулаагүй байгаа тул 2024 онд 9 сургуулийн IY улирлын тайланд тайлагнаагүй байна: Дархан-Уул аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025.02.14-ны 48 тоотод 2024 онд Минж проперти ХХ-ийн гүйцэтгэсэн "Сургуулийн барилгын өргөтгөл , 320 суудал /Дархан-Уул , Дархан сум , 9 сургууль " төсөл арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тул Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах , бүртгэх , данснаас хасах , шилжүүлэх журам"-ын 4.1.2- заасны дагуу ТӨБЗГ-ын хөрөнгө бүртгэх шийдвэрийг хүлээж байгаа талаар дурьдсан байна.

**Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл бичих**

Тус байгууллага нь 2024 онд үдийн хоол хөтөлбөр дээр 318,178.8 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт явуулж, нэг оролцогч оролцон "Их буурагчин" ХХК шалгарч гэрээ байгуулсан байна. Тайлант онд үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэл 316,633.5 мянган төгрөг байна. Мөн англи хэлий пэйрсэн хөтөлбөрийн сурагчдын сургалтын зардал 22,262.3 мянган төгрөгийн нээлтэй тендер зарлаж, нэг орлоцогч оролцон "АЙ И ДИ СИ" ХХК шалгарч гэрээ байгуулсан байна. Тайлан онд англи хэлий пэйрсэн хөтөлбөрийн суралцагсдын сургалтын зардал гүйцэтгэл 22,262.3 мянган төгрөг зарцуулсан байна.

. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд олгох тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын санхүүжилтийн хуваарилалт батлах тухай" А/181 дүгээр тушаалын дагуу нөхөн хангалтын зардлын төсвөөс 100,032.00 мянган төгрөгийг зарцуулсан байна.

1. Ухаалаг самбар 65*-7 ширхэг, 32,830.0 мян. төг
2. Дотоод сүлжээ-ЕБС Загвсяар-17,073.0 т мян.төг
3. Суурин компьютер /i5/- 17 ширхэг, 41,480.0 мян.төг

4. Олон үйлдэлт HP принтер 2 ширхэг, 1,509.0 мян. төг
5. Суурин компьютер /i5/-2 ширхэг, 5,390,000 төгрөгийн 98,282.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем **.tender.gov.mn** системээр дамжуулан захиалан , ерөнхий гэрээний дагуу худалдан авч сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр, ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ" аудит ХХК-д 2025 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 3,474,310.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 69,486.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр сарууддад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, үдийн цай хөтөлбөр, сургалт семинарын зардлаас нийт 603,776.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургууль нь 2024 онд мэдээлбэл зохих 171 мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*__Шийдвэрлэсэн нь__*:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар 4 зөвлөмж нийт 18,774.5 мянган өгсөн зөрчил илэрсэн ба хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 4 | 18,774.5 | 4 | 18,774.5 | 100.0 |
| **Нийт дүн** | **4** | **18,774.5** | **4** | **18,774.5** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал нь 2024 оны эцэст төвлөрүүлсэн цалингийн зардал 389,214.6 мянган төгрөгийг зарцуулаагүй хэмнэсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 28-нд улсын төсвийн санхүүжилтийг нэмж өгсөнтэй холбоотой байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 178,030.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 46,493.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,218.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 128,318.2 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.Үүнд:

- 2024 оны Санхүүгийн тайланд тус сургуулийн өргөтгөлийн шинэ байр ашиглалтанд орсонтой холбоотой БЕГ-ын хөрөнгө оруулалтаар ирсэн 46,493.9 мянган төгрөгийн үнэ бүхий ширээ сандлыг Үндсэн хөрөнгөнд тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 131,319.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 128,318.2 мянган төгрөгийн төлбөрийн зөвлөмж өгч, 3,218.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

### 5.1 Төлбөрийн акт

- Боловсрол, шинжлэх ухааны яамны албан бичгийг үндэслэн /балансын урамшуулал/ Нягтлан бодогч Ц.Отгонцагаан нь балансын шагнал, үр дүнгийн урамшуулал 661,950.0 төгрөг давхардуулан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалттай нийцээгүй нь санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Өндөр насны тэтгэвэрт гарсан багш Т.Долгормаа 787.5 мянган төгрөг, Жү.Батболд 1,050.0 мянган төгрөг, үйлчлэгч Д.Оюунгэрэл 351.0 мянган төгрөг, нягтлан бодогч Ц.Отгонцагаан 367.7 мянган төгрөг нийт 2,556.2 мянган төгрөгийн Төрийн алба хаасаны нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.2, 5.1.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25- ний өдөр 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалттай

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

нийцэхгүй байгаа нь санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.2 Албан шаардлага

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "....санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчиж санхүүгийн тайланг 2025.02.06-.ы өдөр №34 тоот албан бичгээр ирүүлж хугацаа хоцорсон нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.3.1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал**

<u>5.3.1.1 Илрүүлэлт:</u>

Цалингийн тооцооллыг давтан шалгахад Нийгмийн ажилтан Б.Урангоогийн 9 дүгээр сард ноогдох 6 хоногийн ээлжийн амралтын олговор 713,832.0 төгрөгийг Татвар, Нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүйгээс татварт 45,174.0 төгрөг, ниймийн даатгалд 171,320.0 төгрөгийн тооцоог хийгээгүй зөрчил байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалтыг зөрчжээ. НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"гэсэн заалт зөрчсөн.

<u>5.3.1.2 Өгсөн зөвлөмж:</u>

Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

**5.3.2. Бараа материалын данстай холбоотой асуудал**

<u>5.3.2.1 Илрүүлэлт:</u>

Санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл 49,837.4 мянган төгрөгөөр дутуу, 350.0 мянган төгрөгөөр илүү, Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 185,229.4 мянган төгрөгөөр дутуу, тавилга эд хогшил 106,615.0 мянган төгрөгөөр илүү жилийн эцсийн тооллого, илтгэх хуудасны дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." заалт, 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн.

<u>5.3.2.2 Өгсөн зөвлөмж:</u>

Бараа материал дансанд тооллогоор гарсан зөрүүг тухай бүр нь тооцох, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул

[2] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгө дансанд орлого аваагүй | 1 | 46,493.9 | | | | | 1 | 46,493.9 | | | | |
| Дүн | | 46,493.9 | | | | | 1 | 46,493.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой асуудал | 1 | - | - | - | | - | | | 1 | - | - | - |
| Бараа материал, Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал | 1 | 128,101.7 | | | | | 1 | 128,101.7 | | | | |
| Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | 1 | 216.5 | - | - | - | - | 1 | 216.5 | - | - | - | - |
| Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | 1 | 661.95 | 1 | 661.95 | - | - | | | - | - | - | - |
| Зардлын данстай холбоотой асуудал | 1 | 2556.25 | 1 | 2,556.2 | | | | | | | | |
| **Дүн** | **5** | **131,536.4** | **2** | **3,218.2** | | | **2** | **128,318.2** | **1** | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Ахмадын сан байгууулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээ гүй байна. | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |

## ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургууль
Тайлант хугацаа: 2024 он

*Хүснэгт А. АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх*

/төгрөгөөр/

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮТ-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт: Стандартын заалт | Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн заалт | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Санхүүгийн тайлан | Санхүүгийн тайлантай холбоотой асуудал | Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын тайлангаа 2025.02.06-ны 34 тоот албан бичгээр хугацаандаа өгөөгүй болно. | | Тийм | тийм | УСНББОУС-1 | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "....санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" гэсэн заасан заалтыг зөрчсөн | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Хариуцлага тооцох албан шаардлага | | | |
| 2 | Ажил гүйлгээний анги | Бараа материал, Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал | Санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл 49,837,394.39 төгрөгөөр дутуу, 350,000.0 мянган төгрөгөөр илүү, Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 185,229,368.85 төгрөгөөр дутуу, тавилга эд хогшил 106,615,007.21 төгрөгөөр илүү жилийн эцсийн тооллого, илгтэх хуудасны дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн | 128,101,756.03 | Тийм | Үгүй | УСНББОУС-16,17 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2. *"Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулгаж шалгана."* заалт, 67.1 *"Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх барьгч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна."* гэсэн заалтуудыг зөрчсөн. | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Зөвлөмж өгөх | | | |
| 3 | Ажил гүйлгээний анги | Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | Нягтлан бодогч Ц.Отгонцагаан нь балансын шагнал, үр дүнгийн урамшуулал давхардуулан авсан 661,950.0 төгрөг байна. | 661,950.0 | Тийм | Үгүй | УСНББОУС-1 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалтыг зөрчжээ. | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Төлбөрийн акт тогтоох | | | |
| 4 | Ажил гүйлгээний анги | Зардлын данстай холбоотой асуудал | Цалингийн тооцооллыг давтан шалгахад Нийгмийн ажилтан Б.Урангоогийн 9 дүгээр сард ноогдох 6 хоногийн ээлжийн амралтын олговор 713,632.0 төгрөгийг Татвар, Нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүйгээс татварт 45,174.0 төгрөг, ниймийн даатгалд 171,320.0 төгрөгийн тооцоог хийгээгүй зөрчил байна. | 216,494.0 | Тийм | үгүй | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалтыг зөрчжээ.НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"гэсэн заалт зөрчсөн. | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Зөвлөмж | | | |
| 5 | Ажил гүйлгээний анги | Зардлын данстай холбоотой асуудал | Өндөр насны тэтгэвэрт гарсан Багш Т.Долгормаа 787,500.0 төгрөг, Жү.Батболд 1,050,000.0 төгрөг, Үйлчлэгч Д.Оюунгэрэл 351,000.0, нягтлан бодогч Ц.Отгонцагаан 367,750.0 төгрөг нийт 2,556,250.0 төгрөгийн Төрийн алба хаасаны нэмэгдэл хэлс олгосон байна. . | 2,556,250.0 | Үгүй | тийм | Акт | Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.2, 5.1.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25- ний өдөр 07 тоот зөвлөмжийн 6 дугаар заалт | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Төлбөрийн акт тогтоох | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Ажил гүйлгээний анги | Зардлын дансгай холбоотой | Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна. | - | Тийм | Үгүй | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | Ахмад настны тухай хуулийн 14-р зүйлийн14.7 " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан хэрэгжүүлэн ажиллах журмын 1.1, 1.2, .1.3 дахь заалт, 2.1.1 дэх заалтуудыг зөрчсөн зөрчил илэрсэн. | Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал. | Зөвлөмж | | | |
| Дүн | | | | 131,536,450.03 | | | | | | | | | |

*Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш АГАДҮТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх*

| № | Тодорхойлсон эрсдэл | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| 1 | Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх | 2024 оны Санхүүгийн тайланд тус сургуулийн өргөтгөлийн шинэ байр ашиглалтанд орсонтой холбоотой БЕГ-ын хөрөнгө оруулалтаар ирсэн 46,493,924.40 төгрөгийн үнэ бүхий ширээ сандлыг Үндсэн хөрөнгөнд тайлагнаагүй тул залруулав. | 46,493,924.40 | Материаллаг | Тийм | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Санхүүгийн тайланд залруулах | | | |
| Дүн | | | 46,493,924.4 | | | | | | | | | |

**Бэлтгэсэн:**
Аудитор — Б.Хоролбат
Огноо:

**Хянасан:**
Чанарын хяналтын менежер — Л.Магсаржалам
Огноо:

Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК-ийн захирал — С.Оргил
Огноо:

**Танилцаж, зөвшөөрсөн**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дугаар сургууль

Дарга — Т.Орхонтуяа — Огноо:

Нягтлан бодогч — Ц.Отгонцагаан — Огноо:

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 он 02 сар 25 өдөр Дугаар 01/41-25/20082 ... Дархан сум

Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн нягтлан бодогч Ц.Отгонцагаан 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын тайланг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 34 тоот албан бичгээр хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох*" журмын 4.2.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангаа хугацаанд нь ирүүлээгүй нягтлан бодогч Ц.Отгонцагаанд хуульд нийцүүлэн арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид хуулийг хэрэгжүүлж, ажиллахыг Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн захирал Т.Орхонтуяад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.ОРГИЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Л.МАГСАРЖАЛАМ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ш.МӨНХБАЯР

4725040031

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
# АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр                    Дугаар 01/142-25720082-ДАА-2025/103/КА-СТА-2013 Дархан сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургуулийн нягтлан бодогч Ц.Отгонцагаанд үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 661,950.00 төгрөгийн балансын шагнал, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 4 албан хаагчид нийт 3,218,800.00 төгрөгийн төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл тус тус тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *"Хууль тогтоомжид заасанаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"*, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25- ний өдрийн 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчиж олгосон нийт 3,880,750.00 (гурван сая найман зуун наян мянган долоон зуун тавин) төгрөгийг нягтлан бодогч Ц.Отгонцагаанаар, мөн хавсралтад дурдсан албан хаагчдаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн захирал Т.Орхонтуяа , нягтлан бодогч Ц.Отгонцагаан нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ                    С.ОРГИЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:                    Л.МАГСАРЖАЛАМ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:                    Ш.МӨНХБАЯР

452505030

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
9 ДҮГЭЭР СУРГУУЛЬ

45049 Дархан, Дархан-Уул аймаг, 12 дугаар баг
утас: 7037-2990
Web: http://www.Darkhan9.edu.mn

2025.02.06 № 34

танай ____ -ны № ____ т

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ
ЭЗШ АУДИТ ХХК-Д

Тус сургуулийн 2024 оны тушаал, санхүүгийн тайлан, холбогдох баримтуудыг хүргүүлэв.

ЗАХИРАЛ Т.ОРХОНТУЯА

D/Alban ajil/a5